



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.2.1.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны "Дүрэм баталж, тогтоолд нэмэлт оруулах тухай" 143 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол судлалын үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 4.8 дахь хэсэг, Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2022 оны "Төлөвлөгөө батлах тухай" 01 тоот тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны "Хөтөлбөр арга хэмжээний 2022 оны төсвийн жагсаалт, хуваарилалт батлах тухай" А/149 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол судлалыг дэмжих үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөө"-ний 2.2-2.14, 3.1, 3.2, 3.4-3.8-д заасан арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх, төсвийг зарцуулах, хяналт тавих эрхийг хавсралт ёсоор шилжүүлсүгэй.

2. Арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, танилцуулахыг эрх шилжсэн байгууллагын төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан зардал болох нийт 1,492,800.000,0 /нэг тэрбум дөрвөн зуун ерэн хоёр сая найман зуун мянга/ төгрөгийг монгол судлалын үйл ажиллагааг дэмжих зардлаас эрх шилжүүлсэн байгууллагад санхүүжилт олгохыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Эрх шилжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Баттогтох/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Энх-Амгалан/-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142210627

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 05 дугаар сарын 12-ны
өдрийн А/68 тушаалын хавсралт

ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Зардлын хэмжээ /мянга. Төг/	Эрх шилжүүлэх байгууллагын нэр
1	2.2.Монгол судлалын уншлагын танхимд дэлхийн монгол судлалын шилдэг бүтээлийн сан бүрдүүлэх	40,000.0	Монгол Улсын Их Сургууль
2	2.3.“Монгол судлалын шилдэг өв” цуврал: Түүхч, доктор Г.Сүхбаатарын судалгааны бүтээлийн судалгаа	30,000.0	
3	2.4. “Монгол судлалын шилдэг өв цуврал: Хэл шинжлэлч, академич Д.Төмөртоогогийн судалгааны бүтээлийн судалгаа	70,000.0	
4	2.5. Монгол судлалын шилдэг өв: Угсаатны зүйч, доктор Х.Нямбуугийн судалгааны бүтээлийн судалгаа	30,000.0	
5	2.11.“Орчин үеийн хэл шинжлэл ба монгол хэл” бүтээлийн судалгаа	40,000.0	
6	2.13.“Монгол Алтайн хадны зургийн геоархеологийн судалгаа ба дижитал сэргээлт” судалгааны төсөл	200,000.0	
	Дүн	370,000.0	
7	2.7. Монгол Улсын үндэсний атлас: англи, монгол хэлээр хөврүүлэх, судалгаа хийх	90,000.0	Шинжлэх ухааны академи
8	2.8. Хар хул хааны балгас эртний хотын туурийн археологийн судалгаа	60,000.0	
9	2.9. “Монгол Улсын түүх” (XX, XXI зуун) бүтээлийн судалгаа	70,000.0	
10	3.2. Шинжлэх ухаан, технологи, инновацийн нэгдсэн цахим сүлжээг үүсгэх	120,000.0	
11	3.8. “XIII-XIV зууны Монголын эзэнт гүрэн-Их Вьет улсын харилцааны сурвалж бичгийн судалгаа”	20,000.0	
	Дүн	360,000.0	
12	2.10. Монгол Улс дахь монгол хэл, аялгууны цогц судалгаа: Хэнтий, Дорнод аймгийн буриад аялгууны хээрийн шинжилгээ зохион байгуулах	30,000.0	МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургууль
13	3.4. “Гадаадад оршин сууж байгаа монгол угсаатнуудын хэл аялгуу, бичиг соёлын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	20,000.0	
	Дүн	50,000.0	

14	2.6. "Монголчууд ба Исламын ертөнц" нэг сэдэвт бүтээлийн судалгаа	32,000.0	ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль
	Дүн	32,000.0	
15	3.5. Эзэн Чингис хааны мэндэлсний 860 жилийн ойд зориулсан цогц арга хэмжээ	450,000.0	Олон улсын монгол судлалын холбоо
16	3.6. Эх орон, үндэстнийхээ түүх, хэл, соёлоо бахархан дээдлэх үзлийг залуу үеийнхэнд төлөвшүүлэх сургалт, тойрон аялал зохион байгуулах	40,800.0	
	Дүн	490,800.0	
17	2.12. Соёл урлагийн тайлбар толь: VII боть "Телевиз", VIII боть "Номын сан" бүтээлийн судалгаа	40,000.0	Соёл урлагийн их сургууль
	Дүн	40,000.0	
18	3.7. "Хүннүгийн Луут хот"-ын төсөл	60,000.0	Улаанбаатарын их сургууль
19	2.14. Уран зохиолын нэвтэрхий толь 3 боть бүтээл	50,000.0	
	Дүн	110,000.0	
20	3.1. "Хориг уулын эрдэнэс" төсөл	40,000.0	Соёлын өвийн үндэсний төв
	Дүн	40,000.0	
	НИЙТ ДҮН	1,492,800.0	